

БАТЛАВ.
БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Б.АРИУН-ЭРДЭНЭ

2022.05.16

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ,
ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ
ХӨГЖҮҮЛЭХ АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ
ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ**

2022 оны 05-р сарын 16-ны өдөр

№ . 07. /2022

Булган сум.

Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх заалт, Засгийн газрын 2015 оны 430, 2016 оны 179 дүгээр тогтоол, Булган аймгийн Засаг даргын "Шинэ хөгжлийн зам" 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрүүдийг үндэслэн нэг талаас Булган аймгийг төлөөлж Бүрэгхангай сумын Засаг дарга М.Бадам нөгөө талаас "Вайнд майнд" ХХК-ийг төлөөлж гүйцэтгэх захирал ажилтай Ганболд овогтой Ариунболд /цаашид компани гэх/ нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1.Энэхүү гэрээгээр талууд байгаль орчныг хамгаалах, орон нутгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх, уул уурхайн олборлолт, боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах чиглэлээр хамтран ажиллах, ажлын уялдаа холбоог сайжруулахтай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2.Компани нь тухайн тусгай зөвшөөрлийн талбай орших сумын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, орон нутгийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.
- 1.3.Энэхүү гэрээ нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах тухай, Ашигт малтмалын тухай, Газрын тухай, Газрын хэвлийн тухай, Татварын тухай хууль болон бусад хууль, тогтоомжийн хүрээнд явагдана.

ХОЁР. ХАМРАХ ХҮРЭЭ

- 2.1.Гэрээний хамрах хүрээг Булган аймгийн нутаг дэвсгэрт хэрэгжиж байгаа компанийн доор дурьдсан үйлдвэр, уурхайн төсөл (цаашид "төсөл" гэх)-үүдийн үйл ажиллагааны хүрээнд буюу үйлдвэр залгах хүртэлх хугацаанд орон нутагтай хамтран ажиллах гэрээ гэж ойлгоно. Үүнд:
 - 2.2.Хамтран ажиллах гэрээг хэрэгжүүлэхэд Талууд дараах үндсэн чиглэлүүдийг баримтална. Үүнд:
 - 2.2.1.Уурхай, төслийн бүтээн байгуулалттай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх,
 - 2.2.2.Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх,
 - 2.2.3.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх,
 - 2.2.4.Орон нутгийн жижиг дунд бизнес, хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажилд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах,
 - 2.2.5.Соёлын өвийг хамгаалах,
 - 2.2.6.Боловсрол, эрүүл мэндийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах

- 2.3. Нутгийн захиргааны байгууллага нь компанийн үйл ажиллагаанд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу дэмжлэг үзүүлж, хамтран ажиллана.
- 2.4. Талууд хамтран энэхүү гэрээний 2.2.1-2.2.3-т заасан асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэг явуулж болно.
- 2.5. Компани нь тусгай мэргэжил шаардахгүй ажлын байрыг нэн тэргүүнд үйлдвэр, уурхай байрлаж буй сумын иргэдэд санал болгох, дараагийн шатанд зэргэлдээх сумдын иргэдийг ажлын байраар хангах замаар орон нутгийн иргэдийг авч ажиллуулахад анхаарч ажиллана.
- 2.6. Компани нь төслийн үйл ажиллагааны нөлөөнд өртсөн орон нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах үүднээс орон нутгийн бизнесийг дэмжих төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх талаар хамтран ажиллана.

ГУРАВ. ЗАСАГ ДАРГЫН ЭРХ, ҮҮРЭГ

3.1.Ерөнхий зүйлс:

- 3.1.1. Ашигт малтмалын олборлолт, боловсруулах үйлдвэрлэл явуулах хугацаанд тус компанид хууль тогтоомжийн хүрээнд төрийн үйлчилгээ үзүүлж, хяналт тавьж ажиллана.
- 3.1.2. Аж ахуйн нэгж, байгууллагын захиалгаар мэргэшсэн ажилтан бэлдэхэд дэмжлэг үзүүлнэ.
- 3.1.3. Шинэ ажлын байр нэмэгдүүлж буй ажил олгогчийг урамшуулан дэмжинэ.
- 3.1.4. Компанийг ашигт малтмал олборлох, үйлдвэр уурхай байгуулах, цаашид үйл ажиллагаагаа тогтвортой, хэвийн явуулахад орон нутгийн холбогдох байгууллага, албан тушаалтны зүгээс шаардагдах үйлчилгээг шуурхай үзүүлж, дэмжлэг үзүүлнэ.
- 3.1.5. Аймаг, сумын хөгжилд оруулсан хөрөнгийн зарцуулалтыг жил бүр тооцож, ил тод мэдээллэнэ.
- 3.1.6. Уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэн байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологийг бүхий л хэлбэрээр дэмжинэ.
- 3.1.7. Орон нутгийн иргэдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг аж ахуйн нэгж, байгууллагад сурталчилна.
- 3.1.8. Татварын хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох саналыг хамтран хүргүүлнэ.

3.2. Дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр.

- 3.2.1. Уурхай, төслийн дэд бүтцийн үйл ажиллагаатай холбогдуулан гаргасан хүсэлтийг шуурхай шийдвэрлэн компанийн үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөл бололцоогоор хангана.
- 3.2.2. Уурхайн жигд, тогтвортой үйл ажиллагааг хангах, өргөтгөх, ашиглахаар гаргасан хүсэлтийг шуурхай шийдвэрлэн, шаардлагатай дэмжлэгийг үзүүлж ажиллана.
- 3.2.3. Уурхайн үйл ажиллагаанд шаардлагатай газрыг эзэмших, ашиглах хүсэлтийг түргэн шуурхай шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.
- 3.2.4. Уурхайн орчны аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн эсэхэд хяналт тавьж ажиллана.

3.3. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр.

- 3.3.1. Компанийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана.
- 3.3.2. Компаниас орон нутагт зохион байгуулж байгаа байгаль орчны чиглэлийн танилцуулга, сургалт, өдөрлөгт иргэд, олон нийтийг идэвхтэй оролцуулна.
- 3.3.3. Байгаль орчинд ээлтэй, ногоон бизнесийн үйл ажиллагаа, дэвшилтэт технологийг бүхий л хэлбэрээр дэмжих, баталгаажуулахад туслаж, урамшуулна.

3.4. Хөдөлмөр эрхлэлт, ажлын байрыг нэмэгдүүлэх, ажиллах хүчнийг сургах чиглэлээр.

- 3.4.1. Компанийн захиалгаар мэргэшсэн ажилтан бэлтгэхэд дэмжлэг үзүүлэх.
- 3.4.2. Компанийн зарласан ажлын байрны мэдээллийг иргэдэд ил тод, нээлттэй хэлбэрээр хүргэх ажлыг зохион байгуулах, орон нутгийн телевиз, радио, сонингоор түгээх.
- 3.4.3. Төслийн бүтээн байгуулалт, туршилт тохиргоо, зүгшрүүлэлтийн ажил, зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээгээр зайлшгүй ажиллах шаардлагатай гадаад, дотоод ажиллагсдын хөдөлмөр эрхлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.

3.5. Орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулах чиглэлээр.

- 3.5.1. Компанийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод, нээлттэй хэлбэрээр хүргэх ажлыг зохион байгуулах;
- 3.5.2. Компанийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон шалгуур үзүүлэлт, тавигдах шаардлагуудыг орон нутгийн бизнес эрхлэгч, иргэдэд танилцуулахад хамтран ажиллах.

ДӨРӨВ. КОМПАНИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1. Ерөнхий зүйлс.

- 4.1.1. Уурхай, төслийн хүрээн дэх үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулахад орон нутгийн зүгээс аливаа саад тотгор учруулсан тохиолдолд компани нь холбогдох байгууллагаар уг асуудлыг шийдвэрлүүлэх эрхтэй.
- 4.1.2. Ажиллагсдыг гэнэтийн ослын болон эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулж, нийгмийн даатгал болон хүн амын орлогын албан татварыг орон нутагт төлнө.
- 4.1.3. Хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй иргэн, одой хүнийг ажлын байраар хангах буюу ажиллуулаагүй бол холбогдох хууль, тогтоомжийн дагуу мөнгөн төлбөрийг орон нутгийн ХЭДС-д төлнө.
- 4.1.4. Монгол Улсын хуулийн дагуу орон нутгийн албан татварыг тайлагнаж, нийгмийн даатгалын болон татварын өр төлбөргүй ажиллана.
- 4.1.5. Гамшиг, осол, гал түймэр гарсан үед сайн дурын үндсэн дээр тухайн сум, орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон шаардлагатай бусад туслалцаа үзүүлнэ.
- 4.1.6. Уул уурхайн болон боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагааг сум, орон нутгийн иргэдэд сурталчилна.

4.2. Дэд бүтцийг хөгжүүлэх чиглэлээр.

- 4.2.1. Уул уурхайн бүтээгдэхүүн тээвэрлэх авто тээврийн замын маршрутыг аймгийн Засаг даргаар батлуулж, замыг хайрган хучилттай болгон тогтмол засвар арчилгааг хийж, бүтээгдэхүүн тээврийн авто машинуудыг бүрэн хучлагатай болгоно.
- 4.2.2. Ашигт малтмалын бүтээгдэхүүнийн тээврийг орон нутгийн жолооч, аж ахуйн нэгжээр хийлгэхэд түлхүү анхаарна.
- 4.2.3. Төслийн үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх сумын хот төлөвлөлт болон засаглалыг сайжруулахад аймаг болон сумдын засаг захиргааны байгууллагатай хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлж, орон сууцжуулах хөтөлбөр хэрэгжүүлэхэд болно.
- 4.2.4. Харьяалах дэд бүтцийн асуудлыг шийдвэрлэхэд хоёр тал идэвх санаачлага гарган хамтран ажиллана.

4.3. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр.

- 4.3.1. Төслийн байгаль орчинд үзүүлж буй нөлөөлөл, түүнийг бууруулах, хамгаалах чиглэлээр хийсэн ажлын тайланг орон нутгийн иргэдэд танилцуулна.
- 4.3.2. Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг стандартын дагуу чанартай хийж, хууль бусаар ашигт малтмал олборлосон эзэн холбогдогчгүй эвдэрсэн газрыг нөхөн сэргээхэд дэмжлэг үзүүлнэ.

4.3.3. "Тэрбум мод" үндэсий хөдөлгөөний хүрээнд . . . га талбайг хашиж хамгаалан ширхэг мод тарьж, ургуулна.

4.3.4. Аймаг болон сумдын төрийн байгууллагууд, нутгийн иргэдийг уурхайн нөхөн сэргээлтийн үйл ажиллагаатай танилцуулах ажлыг орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулна.

4.3.5. Уурхай, үйлдвэрлэлд ашиглаж байгаа худгийг бүрэн тоолууржуулж, усны ашиглалтын хяналтыг нэвтрүүлнэ.

4.3.6. Худаг засварлах, шинээр гаргах, булаг хамгаалах зэргээр бэлчээрийн усан хангамжийг сайжруулахад хамтран ажиллана.

4.3.7. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагддаг агаар, ус, хөрсний шинжилгээг Булган аймаг дахь лабораториудаар жилд 1-ээс доошгүй удаа хийлгэнэ.

4.3.8. Сумын төвийн хүн амын усан хангамжийг сайжруулах, эрүүл ахуйн шаардлага хангасан усаар хангахад дэмжлэг үзүүлнэ.

4.3.9. Сумын төвийн нэгдсэн хогийн цэгийг дарж булшлах, хог хаягдлын менежментийг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ.

4.3.10. Ашиглалт, олборлолтын ажлыг ТЭЗҮ, уулын ажлын төлөвлөгөөний дагуу ажиллана

4.3.11. Орон нутгийн засаг захиргаатай хамтран биологийн төрөл зүйлийг хамгаалах, нөхөн сэргээх ажилд хамтран ажиллаж, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

4.4. Хөдөлмөр эрхлэлт, ажлын байр нэмэгдүүлэх, ажиллах хүчнийг сургах чиглэлээр.

4.4.1. Ажлын байрны захиалгыг аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газарт ирүүлж, ажил хайгч бүртгэлтэй иргэдээс ажлын ярилцлага хийх журмаар сонгон авч ажиллуулна.

4.4.2. Орон нутгийн хөдөлмөр эрхлэх боломжгүй зорилтот бүлгийн иргэд, сайн дурын бүлгийг "захиалгат бараа бүтээгдэхүүн нийлүүлж хөдөлмөрийн хөлсийг олгох журмаар" дэмжин ажиллана

4.4.3. Компани нь нарийн мэргэжлийн инженер, техникийн ажиллагсдыг шаардлагатай тохиолдолд дотоод, гадаадын их, дээд сургуульд өөрийн зардлаар сургаж мэргэшүүлж болно.

4.4.4. Компани нь Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулиудад бакалаврын түвшинд суралцаж буй оюутнуудад, сурлага, урлаг, спортын өндөр амжилт гаргасан болон зорилтот бүлгийн хүүхдүүдэд санхүүгийн туслалцаа үзүүлдэг тэтгэлэгт хөтөлбөрийг үргэлжлүүлэн ажиллана.

4.4.5. Компани нь төслийн үйл ажиллагаа явуулж буй сумдын сургууль, цэцэрлэгийг сайжруулахад дэмжлэг үзүүлж, Булган аймаг болон сумдтай хамтран ажиллана.

4.4.6. Компани нь аймгийн иргэдэд мэргэжил олгох, шаардлагатай ур чадвар, мэдлэг, практик туршлага эзэмшүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд аймгийн эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллана.

4.4.7. 2022-2023 оны хичээлийн жилд 10 оюутны сургалтын төлбөр болох 40 сая /дөчин сая/ төгрөгийг аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн 1000 4005 1416 (Төрийн сан)-д 2022 оны 7 дугаар сард багтаан төвлөрүүлнэ.

4.5. Соёлын өвийг хамгаалах чиглэлээр.

4.5.1. Үйл ажиллагааны явцад орон нутгийн ард иргэдийн ёс заншил, өв уламжлалыг хүндэтгэнэ.

4.5.2. Орон нутгаас санал болгосон хэрэгжүүлэх боломжтой соёлын өвийг хамгаалах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллана.

4.5.3. Орон нутгийн уламжлалт ариун дагшин газар буюу сүсэг бишрэлийн хувьд ач холбогдолтой уул, овоо, рашаан ус зэрэг байгалийн онцлог тогтоцуудыг орон нутагтай хамтран хамгаалах, орчны тохижилтыг сайжруулах арга хэмжээг авна.

4.5.4. Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд хамтран ажиллана.

4.6. Орон нутгийн бизнесийн хөгжилд хувь нэмэр оруулах чиглэлээр.

4.6.1. Нутгийн иргэд, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэсэн болон санал болгосон бараа бүтээгдэхүүн хүнсний аюулгүй байдал, эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан тохиолдолд эхний ээлжинд худалдан авах бодлого баримтлана.

4.6.2. Компанид шаардлагатай бараа, материал нийлүүлэх жижиг дунд үйлдвэрийн төсөл, хөтөлбөрийг судлан хэрэгжүүлэх, боломжтой төсөл хөтөлбөрийг дэмжиж ажиллана.

4.6.3. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн /мах, сүү, төмс, хүнсний ногоо/-ийг худалдан авах

4.6.4. Компани нь төслийн нөлөөлөлд өртсөн малчин өрхөд зориулсан малчдын амьжиргааг сайжруулах хөтөлбөрт хамруулах саналуудыг орон нутгийн удирдлагууд, холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран боловсруулж ажиллана.

4.6.5. Гамшиг, осол, гал түймэр гарсан үед сайн дурын үндсэн дээр тухайн сум, орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон шаардлагатай бусад туслалцаа дэмжлэгийг үзүүлнэ.

ТАВ. ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ

5.1. Талууд гэрээг тухай жилийн 2 дугаар улиралд багтаан байгуулж, гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна. Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор аймгийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын дэд зөвлөлд хүргүүлнэ.

5.2. Талууд гэрээний хэрэгжилтийг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор дүгнэж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн танилцуулна.

5.3. Орон нутгаас энэхүү гэрээнд заагаагүй буюу Компанийн үүрэг хүлээгээгүй асуудлаар аливаа хүсэлт гаргасан, хандив, тусламж хүссэн, мөн заагдаагүй асуудлаар хамтарч ажиллах тохиолдолд Компани энэхүү гэрээгээр хүлээсэн үүрэгтээ дүйцүүлэн тооцох бөгөөд дүйцүүлэн тооцсон үүргийг гүйцэтгээнд тооцно.

ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

6.1. Талууд үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийг удирдлага болгоно.

6.2. Энэхүү гэрээг биелүүлэхэд хоёр тал санаачилга гаргаж ажиллана.

6.3. Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

6.4. Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь компанийг хуулиар хүлээсэн бусад үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

ДОЛОО. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

7.1. Гэрээг тайлбарлах болон гэрээний хэрэгжилттэй холбоотой маргаан, зөрчлийг тухай бүр, эв зүйгээр шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

7.2. Хэрэв маргаантай асуудлаар талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлнэ.

НАЙМ. БУСАД

8.1. Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

8.2. Давтагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно. Энэ тухайгаа нэг сарын өмнө нөгөө талд бичгээр мэдэгдэнэ.

8.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд зөвхөн бичгээр нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

8.4. Хэрэв гэрээнд ямар нэгэн өөрчлөлт оруулах шаардлага гарвал нөгөө талдаа 30 хоногийн өмнө харилцан бичгээр мэдэгдэнэ. Оруулсан нэмэлт өөрчлөлтийг гэрээнд хавсаргаснаар нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд гэрээний салшгүй хэсэг болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

БҮРЭГХАНГАЙ СУМЫН ЗАСАГ

ДАРГА



"ВАЙНД МАЙНД" ХХК -ИЙН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

